

## **МУИС-ИЙН НЭРЭМЖИТ ЯПОН ХЭЛНИЙ УЛСЫН АНХДУГААР ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

**Зохион байгуулагч:** МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Ази судлалын тэнхим

**Хамтран зохион байгуулагч:** Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо

### **НЭГ: ЗОРИЛГО**

Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, Монгол Улсын Их Сургууль үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд зохион явуулж буй япон хэлний улсын олимпиадыг зохион байгуулах гэж байна. Тус олимпиад нь их, дээд сургууль, коллежид суралцаж буй оюутнуудын япон хэлний болон Япон орны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, япон хэл сурах хүсэл тэмүүллийг дэмжих, сургууль хоорондын харилцаа холбоог бэхжүүлэн Монгол дахь япон хэлний сургалтыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

### **ХОЁР: ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА**

Япон хэлтэй мэргэжилтэн бэлтгэдэг улсын болон хувийн их, дээд сургууль, коллежид суралцаж буй оюутнууд хамрагдана. Олимпиадыг 2022 оны 12-р сарын 17-ны 09:00 цагт МУИС-ийн хичээлийн 2-р байрны 343 тоот танхимд зохион байгуулна.

### **ГУРАВ: ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

1. Олимпиадыг хоёр хэсэгтэй зохион байгуулна. Сургууль тус бүрээс 5 хүний бүрэлдэхүүнтэй 1 баг бүрдүүлж оролцоно. Баг бүр нэр болон уриатай байх бөгөөд мэндчилгээ бэлдэж ирнэ.

1-р хэсэг: Япон хэлний бичгийн шалгалт ( Ханз, үгийн сан, хэлзүйн дүрэм, уншиж ойлгох мэдлэг )

2-р хэсэг: Японы соёл, орон судлалын талаарх мэдлэг шалгах. ( Асуулт, хариулт )

1. Үнэлгээ өгөх аргачлал

1. Бичгийн шалгалт 50 оноо (Багийн гишүүдийн авсан онооны дунджаар тооцно.)

2. Мэдлэг шалгах асуулт 50 оноо (Японы соёл, орон судлалын асуултад зөв хариулсан нийлбэр оноогоор тооцно. )

### **ДӨРӨВ: ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Олимпиадад оролцсон багуудаас нэгдүгээр байр 1, хоёрдугаар байр 1, гуравдугаар байр 1-ийг тус тус шалгаруулна. Багийн нийт онооны дарааллаар байр эзлүүлнэ.

1-р байр 900,000₮, өргөмжлөл

2-р байр 700,000₮, өргөмжлөл

3-р байр 500,000₮, өргөмжлөл

### **ТАВ: БҮРТГЭЛ**

Олимпиадад оролцох тухай албан хүсэлтийн хариуг сургуулийн захиргаанаас 2022 оны 11 сарын 10-ний өдөр мэдэгдэнэ. Багийн мэдүүлгийг 2022 оны 11-р сарын 25-28-ны

өдөр 17:00 цагаас өмнө олимпиад зохион байгуулах комиссын цахим хаяг руу илгээнэ.  
Мэдүүлэгт багийн гишүүдийн овог нэр, анги, япон хэлний түвшин гэх зэрэг  
мэдээллийг хариуцаж буй багш нь тодорхой бичиж явуулна.

Цахим хаяг: [maisuld.d@num.edu.mn](mailto:maisuld.d@num.edu.mn)

Утас: 99277516, 99151118

МУИС, ШУС, Ази судлалын тэнхим

Монголын япон хэлний багш нарын холбоо

Олимпиад зохион байгуулах комисс